

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий
газрын даргын 2016 оны 3-р сарын 18-ний
өдрийн А/239 тоот тушаалаар батлав.

**АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГО
АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР**

Улаанбаатар

2016 он

АГУУЛГА

1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР
2. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР
3. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР
4. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

ХАВСРАЛТ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНБТ-1

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын ажлын хэсэгт хүлээлгэж өгнө.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1 Хяналтын хэсэг

Тоологчийн нэр, код: Тоологч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө “код” баганын харгалзах 3 нүдэнд нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол “”01, “011” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч, кодлогч, шивэгчийн үүргийг нэг хүн хавсран гүйцэтгэж болно.

Шалгагчийн нэр, код: Шалгагч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол “”01, “011” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч асуулгын хуудас үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон үсрэлтүүд зөв байгаа эсэхийг хянаж, тоологчтой хамтран алдааг засварлана.

Кодлогчийн нэр, код: Кодлогч нь алдаагүй зөв болсон асуулгын хуудсыг кодлохоос өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол “”01, “011” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээж бичнэ.

Кодлогч аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, хороолол, бүсчлэлийн код, үүсгэн байгуулагдсан байдал, үйл ажиллагааны чиглэл, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг зэргийн кодлолтыг энэхүү зааврын хавсралтыг ашиглаж хийнэ.

Шивэгчийн нэр, код: Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шивэгч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол “”01, “011” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээн бичнэ.

Мэдээллийг компьютерт оруулах явцад алдаатай мэдээлэл илэрвэл харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсэгт мэдэгдэж, засварласны дараа уг асуулгын хуудасны мэдээллийг компьютерт шивнэ.

1.2 Нэрийн хэсэг

Тухайн аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар, байгуулагдсан огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, хариуцлагын хэлбэрийг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг

үндэслэн үнэн зөв нөхнө. Мөн энэ хэсэгт аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэр, үүсгэн байгуулагдсан хэлбэрийг нөхнө.

Хариуцлагын хэлбэр

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж түүн дээр бичигдсэн байдлаар нь харж нөхнө. Жишээ нь “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн бол ХХК, компани гэж товчилж, үгийг хасч бичихгүй.

Тохирох кодыг кодлогч “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө. Хариуцлагын хэлбэрийг “хоршоо” гэж нөхсөн бол 2.4 асуултыг заавал нөхнө.

Гадаадын компани, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээд болж асуулганд хамрагдана.

Өмчийн хэлбэр

Тухайн аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Харин өмчийн хэлбэр нь төрийн хамтарсан бол төрийн өмчийн эзлэх хувийг, орон нутгийн хамтарсан бол орон нутгийн өмчийн эзлэх хувийг, хувийн хамтарсан бол гадаадын өмчийн эзлэх хувийг нөхөж гадаад улсын нэрийг нөхнө. Хувийг нөхөхдөө харгалзах 3 нүдэнд нөхнө. Хэрэв хоёр оронтой бол “051” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээн бичнэ. Кодлогч тухайн улсын код болон бусад кодуудыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

- Монгол Улсын **”Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”** хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд” гэнэ.
- Монгол Улсын **”Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”** хуулийн 21 дүгээр зүйлийн 1-р хэсэгт зааснаар “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэнэ.
- Монгол Улсын **”Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”** хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулна.

Үүсгэн байгуулагдсан хэлбэр

Тухайн аж ахуйн нэгжийн хэрхэн үүсгэн байгуулагдсан нөхцлийг бичнэ. Үүсгэн байгуулагдсан хэлбэрийн тохирох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж кодлогч нөхнө. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулж болно.

1.3 Аж ахуйн нэгжийн хаягийн хэсэг

Аж ахуйн нэгжийн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хаалганы дугаар, бүсчлэлийн нэр, утасны дугаар, факс, шуудангийн хайрцаг, цахим шуудангийн хаяг, цахим хуудас /вэб/-ны нэр зэргийг бичнэ. Кодлогч тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын

хавсралтаас харж нөхөх ба хэрэв тухайн аж ахуйн нэгж оршин байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн нэр нь хавсралтанд байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй тохиолдолд УБСЕГ-ын ААНБ-ын тооллогын ажлын хэсгийн гишүүдтэй холбоо барьж тохиролцсоны үндсэн дээр кодолно.

1.4 Аж ахуйн нэгжийн дарга/захирлын овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг асууж нөхнө.

2. ЕРӨНХИЙ АСУУЛГА

2.1. Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал

Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг тодорхойлж тохирох хариултыг сонгоно. Кодлогч тохирох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө. Тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг **“Үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа”** гэж үзнэ. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж нь тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй бол **үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна** гэж үзнэ. Тухайлбал, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг тооллогод хамруулах хугацаанд улирлын байдлаас хамаарч үйл ажиллагаагаа түр зогссон байвал тухайн аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна гэж үзнэ. “Үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа” буюу “1”-р хариултыг сонговол 2.3-т шилжинэ. Харин “Үйл ажиллагаа явуулаагүй” буюу “2”-р хариултыг сонговол дараагийн асуулт буюу үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг асууна.

2.2 Үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан

Тухайн аж ахуйн нэгж ямар шалтгааны улмаас үйл ажиллагаагаа явуулаагүй болохыг асууж тохирох хариултыг сонгоно. **“Үйл ажиллагаа эхлээгүй”** гэсэн асуулгад үүсгэн байгуулагдснаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээд, түүний салбар нэгжийг ойлгоно. **“Үйл ажиллагаа түр зогссон”** гэж 18 сар хүртэлх хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нэгж хамрагдана. **“Үйл ажиллагаа бүрэн зогссон”** гэдэгт 18-с дээш сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн нэгж байна. Мөн “Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай”, “Үйлдвэр үйлчилгээ эрхлэх байргүй” гэсэн шалтгаанууд байна. Дээрх шалтгаануудаас өөр шалтгаантай бол хариултыг “Бусад” гэсэн хэсэгт нөхөж бичнэ.

2.3 Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа байрныхаа эзэмшлийн хэлбэрийг тодорхойлно уу гэсэн асуулгад тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа байрны эзэмшлийн хэлбэрийг өөрийн эзэмшлийн, түрээсийн, бусад, тогтсон байргүй гэсэн 4 хэлбэрээс тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол байрны эзэмшлийг тодорхойлж бичнэ.

2.4 Хоршооны үндсэн үзүүлэлтийг нөхнө үү.

Тоологч энэ асуулгыг 1.2-р хэсгийн хариуцлагын хэлбэрийг шалгаж “Хоршоо” бол энэ асуулгыг нөхнө. Тухайн хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нөөцийн сан, тусгай сангийн бүрдүүлэлт, олгосон зээлийн хэмжээг мян.төг-өөр илэрхийлэн нөхнө. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зөвхөн хувь нийлүүлсэн гишүүдийн хөрөнгийн хэмжээгээр бичих бөгөөд хандив, тусламжаар нийлүүлэгдсэн хөрөнгийг хэмжээг энд оруулуулахгүй.

Нөөцийн сан- тухайн хоршооны ашгаас 20 хувиар бодож бий болгосон эрсдэлийн сангийн хэмжээг бичнэ.

Тусгай сан-хоршооны бий болгосон нөөц сангаас бусад сангуудын хөрөнгийн дүнг бичнэ. Тухайлбал, хуваарилагдаагүй орлого, бэлэглэсэн хөрөнгө, хандив, нийгмийн хөгжлийн сан болон тухайн жилийн цэвэр ашиг зэрэг бичигдэнэ.

Хоршооны гишүүдийн тоо - хоршооны төрлөөс хамааран ялгаатай байна. Тухайлбал, анхан шатны хоршоог 9-с доошгүй иргэн, дундын хоршоог 2-с доошгүй хуулийн этгээд байгуулна.

Олгосон зээлийн хэмжээ- Тоологч 1.2-р хэсгийн хариуцлагын хэлбэрийг шалгаж “Хадгаламж зээлийн хоршоо” гэсэн бол энэ асуулгыг асууж нөхнө. Тухайн хадгаламж зээлийн хоршооны 2015 онд олгосон зээлийн хэмжээг мян.төг-өөр илэрхийлж нөхөж бичнэ.

2.5 Танай аж ахуйн нэгж зээлтэй юу асуулгад тийм үгүй гэж хариулна. Банкны зээл, ХЗХ, ББСБ, иргэн зэрэг эх бүх эх үүсвэрийг хамааруулна.

3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

3.1. Тухайн аж ахуйн нэгжээс компьютер ашиглаж байгаа эсэхийг тогтоон тохирох хариуг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд 3.4-т шилжинэ.

3.2. Тухайн аж ахуйн нэгжээс ашиглаж байгаа компьютерийн тоог суурин, зөөврийн гэж төрлөөр нь ялгаж асууна. Бүгд дүн дээр суурин, зөөврийн компьютерийн тооны нийлбэр дүн тавигдана.

3.3. Тухайн аж ахуйн нэгжээс нийт компьютер ашиглаж байгаа ажиллагчдын тоог асууж нөхнө.

3.4. Тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа интернет ашигладаг эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-р хариуг сонговол 4.1-д шилжинэ.

3.5. Интернет холболтын төрлийг асууж, тохирох төрлийг сонгоно. Интернет холболтын төрлийг дараах байдлаар ангилна. Үүнд:

Нарийн зурвас

Өргөн зурвасын суурин интернет

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет

Нарийн зурвас - аналогийн модем (телефон утасны шугамаар дамжуулан), ISDN (дигитал сүлжээний нэгдсэн үйлчилгээ), 256 кбит/с-ээс бага хурдтай DSL, 256 кбит/с-ээс бага хурдаар ачааллах холболтын бусад хэлбэрүүд, хөдөлгөөнт утас зэргийг багтаана.

Өргөн зурвасын суурин интернет -мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа зурвасыг хамарна.

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет - мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа хөдөлгөөнт

технологи (WCDMA, HSDPA, CDMA2000 1xEV-DO, CDMA 2000 1xEV-DV, mobile WiMax, WiBro гэх мэт) ашиглан холбогдож байгаа зурвасыг багтаана.

3.6. Тухайн аж ахуйн нэгжийн интернет хэрэглэгчдийн тоог асууж нөхнө.

3.7. Интернетээр захиалга авч, үйлчилгээ үзүүлдэг үү? Асуулгыг дараах төрлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Интернетээр захиалга авах, үйлчилгээ нь интернетийн сүлжээгээр төлбөртэй болон төлбөргүйгээр хүлээн авсан захиалга байна. Үүнд вэбсайт, интернет, экстранэт, интернет утас болон цахим шуудангаар хүлээн авсан захиалга, үйлчилгээ багтана. Тухайлбал, интернет худалдаа эрхлэх, интернетээр болон цахим шуудангаар бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ захиалгыг авах, интернетээр сургуульд болон сургалтын төвд бүртгүүлэх, эмнэлэгт үзүүлэх дугаар авах, онлайнгаар билет захиалах гэх мэт үйлчилгээ байна.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015 оны дүнгээр

4.1 Тухайн аж ахуйн нэгжид 2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалт байгаа эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Энэ асуулгад “Үгүй” гэж хариулсан тохиолдолд 5.1-д шилжинэ.

4.2 Тухайн аж ахуйн нэгжийн гадаадын ажиллагчидтай эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-аар хариултыг сонговол 4.5-д шилжинэ.

4.3 Тухайн аж ахуйн нэгжийн гадаадын ажиллагчдын тоог нөхнө.

4.4 Гадаадын ажиллагчдад олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээг асууж мян.төг-өөр илэрхийлэн нөхнө.

4.5 Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардлын хэмжээ, 2015 оны дүнгээр

Тухайн аж ахуйн нэгжийн 2015 онд байгаль хамгаалахад зарцуулсан зардлын хэмжээг асууж мян.төг-өөр илэрхийлж бичнэ. Байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалахтай холбогдон гарсан байгаль орчныг хамгаалах менежмент, байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээ, аудит, байгаль орчны стандартыг нэвтрүүлэхтэй холбогдон гарсан зардал, байгаль орчны хохирлын нөхөн төлбөр, торгуульд зарцуулсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг байгаль хамгаалах зардалд хамруулна.

Үйл ажиллагааны зардалд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа ажиллагчдын цалин хөлс болон зарцуулсан түлш шатахуун, цахилгаан эрчим хүч, хангамжийн бараа, материал, үйлчилгээний зардал багтана.

Хөрөнгө оруулалтын зардалд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд зориулан худалдан авсан машин, тоног төхөөрөмж болон түүний суурилуулалтын зардал багтана.

4.6 Тухайн аж ахуйн нэгж 2015 онд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-аар хариултыг сонговол 4.9-д шилжинэ.

4.7 Хөрөнгө оруулалтын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү.

Хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм. Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт** гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;
- **Өөрийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;
- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, буцалтгүй болон тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсаны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессийн гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мян.төг-өөр үнэлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ.

4.8 Хөрөнгө оруулалтын хэмжээг хөрөнгийн ангиллаар нөхнө үү.

Тухайн аж ахуйн нэгжийн тайлант жилд шинээр бий болсон хөрөнгийг энд хамааруулна. Үүнд:

Үйлдвэрлэгдэх хөрөнгө:

- Үндсэн хөрөнгө
 - Орон сууцны барилга
 - Орон сууцны бус барилга
 - Бусад байгууламж
 - Газар, хөрс сайжруулалт
 - Тээврийн хэрэгсэл
 - Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж
 - Тавилга, эд хогшил
 - Бусад машин, тоног төхөөрөмж
 - Биологийн өсөж, үрждэг хөрөнгө

- Оюуны өмчийн хөрөнгө:
 - Геологи хайгуулын ажил, үнэлгээ
 - Компьютерийн програм хангамж, мэдээллийн сан
 - Оюуны өмчийн бусад хөрөнгө
- Материаллаг эргэлтийн хөрөнгө
- Үнэт зүйлс

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө:

- Байгалийн нөөц, баялаг
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лиценз

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

- Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө - Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брендийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үйлдвэрлэгдэх хөрөнгө, үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн нийлбэр дүн бичигдэнэ. Үндсэн хөрөнгийн эх үүсвэр буюу 4.8-ын “БҮГД” дүн хөрөнгө оруулалтыг ангиллаар буюу 4.9-ийн “БҮГД” дүнтэй тэнцүү байна.

Жич: Дээрх үйлдвэрлэгдэх хөрөнгийн ойлголт, тодорхойлолтыг 4.10 буюу “Хөрөнгийн үзүүлэлт”-тэй ижил утгаар ойлгоно.

4.9 Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 2015 оны дүнгээр

Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэх мэтээр сайтар ялгаж бичнэ. Хэрэв тухайн аж ахуйн нэгж улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэнээс өөр үйл ажиллагаа явуулж байгаа бол явуулж байгаа үйл ажиллагааг нь бичнэ. Жишээ нь: улсын бүртгэлийн гэрчилгээнд “барилга угсралт” гэсэн боловч барилгын материалын жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол тухайн эрхэлж буй үйл ажиллагааг буюу “барилгын материалын жижиглэнгийн худалдаа” гэж дэлгэрэнгүй бичнэ.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл бүрийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн эсвэл борлуулалтын өндөр орлоготой үйл ажиллагааг бага руу нь хуваарилах буюу үйл ажиллагааг ихээхэн бага руу хуваарилах аргаар (Top-down method) тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номноос харж нийслэл, аймгийн тооллогын ажлын хэсгийн гишүүн кодлоно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлого, тухайн үйл ажиллагааг эхэлсэн огноог нөхөж, мэдээ, тайлан гаргадаг эсэхийг тодруулж тохирох хариултыг сонгоно.

2-5-р багануудын дүнг харгалзах баганын “Бүгд” мөрөнд нэгтгэнэ.

Ажиллагчдын тоо нь 2015 оны дундаж тоо байх ба 2-аар баганад нөхнө. Үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог 3-аар баганад нөхнө.

4-р баганад үйл ажиллагааны чиглэл бүрээр тухайн аж ахуйн нэгжээс 2015 онд ажиллагчиддаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлыг мян.төг-өөр ялгаварлан нөхнө. Цалин, түүнтэй адилтгах зардалд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал багтана.

Үндсэн цалин - тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.

Нэмэгдэл - ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл байна.

Нэмэгдэл хөлс - ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.

5-р баганын үйл ажиллагааны орлогыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэж үйл ажиллагааны чиглэл бүрээр мян.төг-өөр ялгаварлан бичнэ.

Үйл ажиллагааны орлогод барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэсэн орлогыг оруулна. 6-р баганад үйл ажиллагааны чиглэл бүрээр мэдээ, тайлан гаргадаг эсэх талаар асууж тохирох хариултыг сонгоно. 7-р баганад үйл ажиллагааны чиглэл бүрийн эхэлсэн огноог бичнэ. Үйл ажиллагаа тус бүрээр эхэлсэн огноог асуух ба үйл ажиллагаа эхэлсэн огноо нь байгуулагдсан огнооноос өмнө бичиж болохгүй. Тоологч “1.2”-с байгуулагдсан огноог тулгаж шалгана..

4.10 Хөрөнгийн үзүүлэлт

Тухайн аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл орсон дүн нөхөгдөнө.

1. **Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг 2015 оны жилийн эцсийн байдлаар элэгдэл орсон дүнгээр мян.төг-өөр тооцож нөхнө.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, газрын сайжруулалт, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил болон өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

1.1 **Орон сууцны барилгад** аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.

1.2 **Бусад барилга, байгууламж** нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ.

1.2.1 **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.

1.2.2 **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.

1.2.2.1 **Авто замыг** бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.

1.2.3 **Газар, хөрс сайжруулалт** нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна. ***Газрын эзэмших эрх шилжихтэй холбогдон гарах зардлыг энд бүртгэнэ.***

1.3 **Машин, тоног төхөөрөмж** нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ.

1.3.1 **Тээврийн хэрэгсэл** нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх

- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
- төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
- нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
- усан онгоц, аяны болон спортын завь
- мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.

1.3.2 **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид** цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.

1.3.3 **Тавилга, эд хогшилд** албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.

1.3.4 **Бусад машин, тоног төхөөрөмжид** ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.

1.4 **Биологийн өсөж үрждэг хөрөнгөд** байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. **Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.**

1.5 **Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал** нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

- Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
- Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;
- Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
- Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
- Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.6 Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилагдана. Үүнд:

1.6.1 **Судалгаа, шинжилгээний ажилд** хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. **Судалгаа шинжилгээ болон**

хөгжлийн ажлын зах зээлийн үнийг шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.

- 1.6.2 **Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд** газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.
- 1.6.3 **Компьютерийн программ хангамж, мэдээллийн санд** худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан программ хангамж, системийн болон хэрэглээний программ хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол программ хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, өөрсдөө боловсруулсан бол үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн зардлаар үнэлнэ.** Программ хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ.
- 1.6.4 **Утга зохиол, урлагийн эх бүтээл** нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.
- 1.6.5 **Оюуны өмчийн бусад хөрөнгө** дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)

2. **Материаллаг эргэлтийн хөрөнгө** нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс байна.

2.1 **Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд** дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2 **Хангамжийн материал нь** үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3 **Дуусаагүй үйлдвэрлэл** нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ.

- 2.3.1 **Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл** нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсч гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор

үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2 **Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд** өсч үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлээс бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4 **Бэлэн бүтээгдэхүүнд** хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиам, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5 **Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд** аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

3. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зорилуултаар эзэмшдэг хөрөнгө байна.

3.1 **Үнэт металл, үнэт чулуу** нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2 **Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл** нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3 **Бусад үнэт зүйлсд** маркны цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засч хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

5. ТОЛГОЙ, ОХИН/ХАРААТ КОМПАНИ, САЛБАР,НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

5.1 Танай аж ахуйн нэгж толгой, охин/хараат компани, салбар төлөөлөгчийн газартай юу асаалгад тухайн аж ахуйн нэгжээс дотоод болон гадаадад толгой компани (харьяалах дээд байгууллага), охин/хараат компани, салбар, төлөөлөгчийн газар (харьяалах доод байгууллага)-тай эсэхийг асууж нөхнө. “2”-р хариулт сонговол асуулгыг дуусгана.

5.2 Тухайн аж ахуйн нэгж дотоодод болон гадаадад салбар, төлөөлөгчийн газар, охин, толгой компанитай нөхцөлд гадаад, дотоодын салбар, төлөөлөгчийн газар, охин, толгой компаний мэдээллийг нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж нь олон салбар, төлөөлөгчийн газар, охин компанитай бол нэмэлт хуудас оруулна.

Үүнд гадаадын аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар хамаарахгүй. Тэдгээрийг бие даасан хуулийн этгээд гэж үзэн үндсэн асуулгын хуудаснаас нөхүүлнэ.

Тоологч Толгой -1, охин/хараат -2, салбар -3, төлөөлөгчийн газар -4 нэгж -5 гэсэн тохирох кодыг сонгож асуулгыг нөхнө.

Толгой, охин/хараат, төлөөлөгчийн газрын мэдээллийг мөрөнд жагсаан бичнэ. Үүнд регистрийн дугаар, нэр, хаягийн мэдээлэл, утасны дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноо гэсэн үзүүлэлт байна. Хаягийн хэсэгт аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хорооны нэрийг нөхөх ба “Хаяг” гэсэн баганад гудамж, хороололын нэр, байр/ байшин, хашаа/хаалганы дугаарыг нөхнө.

- **Толгой компани** (Харьяалах дээд байгууллага) нь аж ахуйн нэгжийн хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан хуулийн этгээд юм.
- Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 1-р хэсэгт заалтын дагуу **Хараат компани** нь компаний нийт энгийн хувьцааны 20-50 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хэлнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.
- Мөн хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 2-р хэсэгт зааснаар “**Охин компани**” нь компаний нийт энгийн хувьцааны 50-с дээш (51-100) хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээд байх бөгөөд охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.
- Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар “**Салбар**” нь толгой компаний оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компаний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.
- **Нэгж** – салбар болон төлөөлөгчийн газар болж чадахгүй, үндсэн аж ахуйн нэгжээс өөр газар үйл ажиллагаа явуулж буй (уурхай, мод бэлтгэл гэх мэт) нэгжийг хамруулж ойлгоно.

Салбар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан толгой компаний нэрийн өмнөөс явуулах ба толгой компани нь өөрийн салбар компанийн хүлээх үүргийг хариуцна.

Салбарын охин/хараат компаниас ялгагдах онцлог нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй. Харин түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

Төлөөлөгчийн газар нь компаний оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компаний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компаний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

5.3 Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Салбар -3, төлөөлөгчийн газар -4 нэгж -5 гэсэн тохирох кодыг сонгож асуулгыг нөхнө. Энд салбар, төлөөлөгчийн газрын регистрийн дугаар, байгууллагын нэр, үйл ажиллагааны чиглэлийн нэрийг

дэлгэрэнгүй нөхнө. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номноос харж нийслэл, аймгийн тооллогын ажлын хэсгийн гишүүн кодлоно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлого, тухайн үйл ажиллагааг эхэлсэн огноог нөхөж, мэдээ, тайлан гаргадаг эсэхийг тодруулж тохирох хариултыг сонгоно. Салбаруудын 2-с 5-р баганы үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогыг мян.төг-өөр илэрхийлэн БҮГД мөрөнд дүнг нэтгэнэ.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, аж ахуйн нэгжийн тамга, тэмдэгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө.

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН

АСУУЛГА ААНБТ-2

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын ажлын хэсэгт хүлээлгэж өгнө.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1 Хяналтын хэсэг

Тоологчийн нэр, код: Тоологч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө тоологчийн код гэсэн баганын харгалзах 3 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч, кодлогч, шивэгчийн үүргийг нэг хүн хавсран гүйцэтгэж болно.

Шалгагчийн нэр, код: Шалгагч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол ""01, "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч асуулгын хуудасны үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон үсрэлтүүд зөв байгаа эсэхийг хянаж, тоологчтой хамтран алдааг засварлана.

Кодлогчийн нэр, код: Кодлогч нь алдаагүй зөв болсон асуулгын хуудсыг кодлохоос өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол ""01, "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Кодлогч аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, хороолол, бүсчлэлийн код, үүсгэн байгуулагдсан хэлбэр, үйл ажиллагааны чиглэл зэргийн кодлолтыг "Асуулга нөхөх заавар"-ын хавсралтыг ашиглаж хийнэ.

Шивэгчийн нэр, код: Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шивэгч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Мэдээллийг компьютерт оруулах явцад алдаатай мэдээлэл илэрвэл харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсэгт мэдэгдэж, засварласны дараа уг асуулгын хуудасны мэдээллийг компьютерт шивнэ.

1.2 Нэрийн хэсэг

Тухайн байгууллагын регистрийн дугаар, байгуулагдсан огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноог улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө. Мөн энэ хэсэгт байгууллагын өмчийн хэлбэр, үүсгэн байгуулагдсан хэлбэр нөхөгдөнө.

Өмчийн хэлбэр

Тухайн байгууллагын өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үндэслэн гаргасан ангиллаас холбогдох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж кодлогч нөхнө.

- Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит хуулийн этгээд**” гэнэ.
- Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1-р хэсэгт зааснаар “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг **төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд**” гэнэ.

1.3 Байгууллагын хаягийн хэсэг

Байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, бүсчлэлийн нэр, оршин байгаа хаяг, утасны дугаар, факс, шуудангийн хайрцаг, цахим шуудангийн хаяг, вэб хуудасны нэр, байшин, байр, хаалганы дугаарыг бичнэ. Кодлогч тэдгээрт тохирох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас авч нөхнө. Хэрэв тухайн байгууллагын оршин байгаа гудамж, хорооллын нэр нь хавсралтад байгаа гудамж, хорооллын жагсаалтад байхгүй, түүнийг нэмэх шаардлага гарвал түүний кодыг УБСЕГ-ын ААНБ-ын тооллогын ажлын хэсгийн гишүүдтэй холбоо барьж тохиролцсоны үндсэн дээр кодолно.

2. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

2.1 Танай байгууллагад ашиглагдаж байгаа компьютер бий юу?

Тухайн байгууллагаас ашиглаж байгаа компьютер байгаа эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” гэж хариулсан тохиолдолд 2.4-д шилжинэ.

2.2 Тухайн байгууллагад ашиглаж байгаа компьютерийн тоог суурин, зөөврийн гэж төрлөөр нь ялгаж асууна. “Бүгд” дээр суурин, зөөврийн компьютерын тооны нийлбэр дүн тавигдана.

2.3 Тухайн байгууллагад нийт компьютер ашиглаж байгаа ажиллагчдын тоог асууж нөхнө.

2.4 Тухайн байгууллага үйл ажиллагаандаа интернет ашигладаг эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-р хариултыг сонговол 3.1-д шилжинэ.

2.5 Интернет холболтын тохирох төрлийг сонгоно. Интернет холболтын төрлийн дараах байдлаар ангилна. Үүнд:

Нарийн зурвас

Өргөн зурвасын суурин интернет

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет

Нарийн зурвас гэдэгт аналогич модем (телефон утасны шугамаар дамжуулан), ISDN (дижитал сүлжээний нэгдсэн үйлчилгээ), 256 кбит/с-ээс бага хурдтай DSL, 256 кбит/с-ээс бага хурдаар ачааллах холболтын бусад хэлбэрүүд, хөдөлгөөнт утас зэргийг багтаана.

Өргөн зурвасын суурин интернет гэж мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа зурвасыг ойлгоно.

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет гэж мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа хөдөлгөөнт технологи ашиглан (WCDMA, HSDPA, CDMA2000 1xEV-DO, CDMA 2000 1xEV-DV, mobile WiMax, WiBro гэх мэт) холбогдож байгаа зурвасыг ойлгоно.

2.6 Тухайн байгууллагын интернет хэрэглэдэг ажиллагчдын тоог асууж нөхнө.

3. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015 оны дүнгээр

3.1 Танай байгууллага 2015 онд хөрөнгө оруулалт хийсэн үү?

Тухайн байгууллага 2015 онд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Тийм” буюу “1”-р хариултыг сонговол дараагийн асуултыг үргэлжлүүлэн асууна. “Үгүй” буюу “2”-р хариултыг сонговол 3.4-т шилжинэ.

3.2 Хөрөнгө оруулалтын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү.

Хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм. Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт** гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;
- **Өөрийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;
- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, буцалтгүй болон тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсаны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессийн гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мян.төг-өөр үнэлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ.

3.3 Хөрөнгө оруулалтын хэмжээг хөрөнгийн ангиллаар нөхнө үү.

Тухайн аж ахуйн нэгжийн тайлант жилд шинээр бий болсон хөрөнгийг энд хамааруулна. Үүнд:

Үйлдвэрлэгдэх хөрөнгө:

- Үндсэн хөрөнгө
 - Орон сууцны барилга
 - Орон сууцны бус барилга
 - Бусад байгууламж
 - Газар, хөрс сайжруулалт
 - Тээврийн хэрэгсэл
 - Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж
 - Тавилга, эд хогшил
 - Бусад машин, тоног төхөөрөмж
 - Биологийн өсөж, үрждэг хөрөнгө
- Оюуны өмчийн хөрөнгө:
 - Геологи хайгуулын ажил, үнэлгээ
 - Компьютерийн програм хангамж, мэдээллийн сан
 - Оюуны өмчийн бусад хөрөнгө
- Материаллаг эргэлтийн хөрөнгө
- Үнэт зүйлс

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө:

- Байгалийн нөөц, баялаг
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лиценз

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

- Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө - Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брендийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үйлдвэрлэгдэх хөрөнгө, үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн нийлбэр дүн бичигдэнэ. Үндсэн хөрөнгийн эх үүсвэр буюу 3.2-ын “БҮГД” дүн хөрөнгө оруулалтыг ангиллаар буюу 3.3-ын “БҮГД” дүнтэй тэнцүү байна.

Жич: Дээрх үйлдвэрлэгдэх хөрөнгийн ойлголт, тодорхойлолтыг 3.5 буюу “Хөрөнгийн үзүүлэлт”-тэй ижил утгаар ойлгоно.

3.4 Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 2015 оны дүнгээр

Тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй, тодорхой бичнэ. Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC-4.0)-аас харж кодлогч нөхнө.

Үйл ажиллагааг тухайн байгууллагын үндсэн эрхлэх үйл ажиллагааны дагуу дарааллуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах орлого гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогыг нөхнө. Эдгээрийг үйл ажиллагааны чиглэл бүрээр тодорхойлох боломжгүй бол үндсэн үйл ажиллагаагаар нөхнө. 2-с 5-р багануудын дүнг харгалзах баганын “Бүгд” гэсэн мөрөнд нэгтгэнэ. Ажиллагчдын тоог 2015 оны дундаж ажиллагчдын тоо байна.

Тухайн асуулгын 4 дүгээр баганад 2015 онд тухайн байгууллагаас ажиллагчиддаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээг мян.төг-өөр тооцож тавина. Цалин, түүнтэй адилтгах зардалд үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллыг оруулна.

Үндсэн цалин гэдэг нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.

Нэмэгдэл гэдэг нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.

Нэмэгдэл хөлс гэдэг нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.

5-р баганад гүйцэтгэсэн үйл ажиллагааны орлогыг мян.төг-өөр тооцож нөхнө. Үүнд төсвийн зардлыг оруулахгүй. Төсвийн байгууллагууд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогод үндсэн бус үйл ажиллагаанаас олсон орлогыг бичнэ. Өөрөөр хэлбэл гадаад валютын ханшны зөрүүгийн олз, хөрөнгө худалдсаны олз, бараа материал, нөөцийн бараа материал худалдсаны олз зэрэг орно.

3.5 Хөрөнгийн үзүүлэлтийг нөхнө үү.

Тухайн байгууллагын нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл орсон дүн нөхөгдөнө.

1. **Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг 2015 оны жилийн эцсийн байдлаар элэгдэл орсон дүнгээр мян.төг-өөр тооцож нөхнө.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, газрын сайжруулалт, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил болон өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

- 1.1 **Орон сууцны барилгад** аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.
- 1.2 **Бусад барилга, байгууламж** нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ.
- 1.2.1 **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.
- 1.2.2 **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.
- 1.2.2.1 **Авто замыг** бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.
- 1.2.3 **Газар, хөрс сайжруулалт** нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна. ***Газрын эзэмших эрх шилжихтэй холбогдон гарах зардлыг энд бүртгэнэ.***
- 1.3 **Машин, тоног төхөөрөмж** нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ.
- 1.3.1 **Тээврийн хэрэгсэл** нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх
- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
 - төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
 - нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
 - усан онгоц, аяны болон спортын завь
 - мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.
- 1.3.2 **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид** цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.
- 1.3.3 **Тавилга, эд хогшилд** албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.
- 1.3.4 **Бусад машин, тоног төхөөрөмжид** ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж,

аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.

1.4 Биологийн өсөж үрждэг хөрөнгөд байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. ***Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.***

1.5 Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

- Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
- Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;
- Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
- Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
- Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.6 Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилагдана. Үүнд:

1.6.1 Судалгаа, шинжилгээний ажилд хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. ***Судалгаа шинжилгээ болон хөгжлийн ажлын зах зээлийн үнийг*** шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.

1.6.2 Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.

1.6.3 **Компьютерийн программ хангамж, мэдээллийн санд** худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан программ хангамж, системийн болон хэрэглээний программ хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол программ хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, өөрсдөө боловсруулсан бол үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн зардлаар үнэлнэ.** Программ хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ.

1.6.4 **Утга зохиол, урлагийн эх бүтээл** нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.

1.6.5 **Оюуны өмчийн бусад хөрөнгө** дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)

2. **Материаллаг эргэлтийн хөрөнгө** нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс байна.

2.1 **Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд** дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2 **Хангамжийн материал нь** үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3 **Дуусаагүй үйлдвэрлэл** нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ.

2.3.1 **Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл** нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсч гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2 **Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд** өсч үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлээс бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4 **Бэлэн бүтээгдэхүүнд** хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний

үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиам, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5 Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

3. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зорилуултаар эзэмшдэг хөрөнгө байна.

3.1 Үнэт металл, үнэт чулуу нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2 Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3 Бусад үнэт зүйлсд маркны цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засч хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, аж ахуйн нэгжийн тамга, тэмдэгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН

ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНБТ-3

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын ажлын хэсэгт хүлээлгэж өгнө.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1 Хяналтын хэсэг

Тоологчийн нэр, код: Тоологч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө тоологчийн код баганын харгалзах 3 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч, кодлогч, шивэгчийн үүргийг нэг хүн хавсран гүйцэтгэж болно.

Шалгагчийн нэр, код: Шалгагч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол ""01, "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч асуулгын хуудасны үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон үсрэлтүүд зөв байгаа эсэхийг хянаж, тоологчтой хамтран алдааг засварлана.

Кодлогчийн нэр, код: Кодлогч нь алдаагүй зөв болсон асуулгын хуудсыг кодлохоос өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Кодлогч аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, хороолол, бүсчлэлийн код, үүсгэн байгуулагдсан хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг зэргийн кодлолтыг "Асуулга нөхөх заавар"-ын хавсралтыг ашиглаж хийнэ.

Шивэгчийн нэр, код: Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шивэгч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол ""01, "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Мэдээллийг компьютерт оруулах явцад алдаатай мэдээлэл илэрвэл харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсэгт мэдэгдэж, засварласны дараа уг асуулгын хуудасны мэдээллийг компьютерт шивнэ.

1.2 Нэрийн хэсэг

Тухайн байгууллагын регистрийн дугаар, байгуулагдсан огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноог улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн нөхнө. Мөн энэ хэсэгт байгууллагын өмчийн хэлбэр, үүсгэн байгуулагдсан хэлбэрийг нөхнө.

Өмчийн хэлбэр. Тухайн байгууллагын өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Өмчийн хэлбэрийн холбогдох кодыг кодлогч “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

1.3 Байгууллагын хаягийн хэсэг

Байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хаалганы дугаар, бүсчлэлийн нэр, оршин байгаа хаяг, утасны дугаар, факс, шуудангийн хайрцаг, цахим шуудангийн хаяг, цахим /вэб/ хуудасны нэрийг бичиж өгнө.

Кодлогч тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхөх бөгөөд байгууллагын оршин байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн нэр нь хавсралтад байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй тохиолдолд УБСЕГ-ын ААНБ-ын тооллогын ажлын хэсгийн гишүүдтэй холбоо барьж тохиролцсоны үндсэн дээр кодолно.

1.4 Байгууллагын дарга/захирлын мэдээлэл

Байгууллагын дарга/захирлын овог, нэр, регистрийн дугаар, суурин утасны дугаарыг асууж нөхнө.

1.5 Төрийн бус байгууллагын төрөл

Төрийн бус байгууллагыг дотор нь нийгэмдээ үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэж ангилна. Нийгэмдээ үйлчилдэг буюу “1” -ийг сонговол 1.6 –р асуултыг заавал асууж нөхнө. Гишүүддээ үйлчилдэг буюу “2”-ыг сонговол 2.1-т шилжинэ.

- **Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага** нь соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг ойлгоно.
- **Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага** нь өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэгээс бусад төрийн бус байгууллагууд байна.

1.6 Үйл ажиллагааны чиг үүрэг

Нийгэмдээ үйлчилдэг төрийн бус байгууллага уг асуулгыг нөхөх ба Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хувьд үйл ажиллагааны төрлийг “Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын олон улсын ангилал (COPNI)”-ын дагуу нөхнө. Кодлогч үйл ажиллагааны чиг үүргийн ангиллыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтыг ашиглан кодолно.

2. ЕРӨНХИЙ АСУУЛГА

2.1 Гишүүдийн тоо

Тухайн төрийн бус байгууллагын гишүүдийн нийт тоо байна. Үүнд гишүүн бус ажиллагчдын тоог оруулахгүй. Жич: Улс төрийн намыг төв байгууллага нь нийт гишүүдийн тоог нөхнө. Харин аймаг, дүүргийн улс төрийн нам нь тухайн салбар намдаа бүртгэлтэй гишүүдийн тоог нөхнө.

2.2 Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал

Тухайн байгууллагын үйл ажиллагаа эрхлэлтийн байдлын тохирох хариултыг сонгоно. Тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа гэж тооцох ба улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь тооллогын хугацаанд үйл

ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна гэж тодорхойлно. Тухайлбал, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг тооллогод хамруулах хугацаанд улирлын байдлаас хамаарч үйл ажиллагаагаа түр зогссон байвал тухайн аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна гэж үзнэ. Асуултын 1-р хариултыг сонговол 3.1-т шилжинэ.

2.3 Үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан

Тухайн байгууллага 2.2-р асуултын 2-р хариултыг сонгосон тохиолдолд үйл ажиллагаа эрхлээгүй шалтгааныг асууж нөхнө. **“Үйл ажиллагаа эхлээгүй”** хариулт нь үүсэн байгуулагдснаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээд, түүний салбар нэгж байна. **“Үйл ажиллагаа түр зогссон”** нь 18 сар хүртэлх хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нэгж хамрагдана. **“Үйл ажиллагаа бүрэн зогссон”** гэж 18-с дээш сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн нэгж хамарна. Мөн “Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай”, “Үйлдвэр, үйлчилгээ эрхлэх байргүй” зэрэг бусад шалтгаануудаас тохирох хариултыг сонгоно. Хэрэв дээрхээс өөр шалтгаантай бол “Бусад” гэсэн хэсэгт бичнэ.

3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

3.1 Тухайн байгууллагаас компьютер ашиглаж байгаа эсэхийг тогтоон тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” гэж хариулсан тохиолдолд 3.4-т шилжинэ.

3.2 Тухайн байгууллагаас ашиглаж байгаа компьютерийн тоог суурин, зөөврийн гэж төрлөөр нь ялгаж асууна. Бүгд дүн дээр суурин, зөөврийн компьютерийн тооны нийлбэр дүн тавигдана.

3.3 Тухайн байгууллагад нийт компьютер ашиглаж байгаа ажиллагчдын тоог асууж нөхнө.

3.4 Тухайн байгууллага үйл ажиллагаандаа интернет ашигладаг эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-р хариуг сонговол 4.1-д шилжинэ.

3.5 Интернет холболтын төрлийг асууж, тохирох төрлийг сонгоно. Интернет холболтын төрлийг дараах байдлаар ангилна. Үүнд:

Нарийн зурвас

Өргөн зурвасын суурин интернет

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет

Нарийн зурвас - аналогийн модем (телефон утасны шугамаар дамжуулан), ISDN (дижитал сүлжээний нэгдсэн үйлчилгээ), 256 кбит/с-ээс бага хурдтай DSL, 256 кбит/с-ээс бага хурдаар ачааллах холболтын бусад хэлбэрүүд, хөдөлгөөнт утас зэргийг багтаана.

Өргөн зурвасын суурин интернет - мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа зурвасыг хамарна.

Өргөн зурвасын хөдөлгөөнт интернет - мэдээлэл илгээх, татах /upload and download/ хурд нь аль нэг талдаа хамгийн багадаа 256 кбит/с-ээр холбогдож байгаа хөдөлгөөнт

технологи (WCDMA, HSDPA, CDMA2000 1xEV-DO, CDMA 2000 1xEV-DV, mobile WiMax, WiBro гэх мэт) ашиглан холбогдож байгаа зурвасыг багтаана.

3.6 Тухайн байгууллагын интернет хэрэглэгчдийн тоог асууж нөхнө.

3.7 Интернетээр захиалга авч, үйлчилгээ үзүүлдэг үү Асуулгыг дараах төрлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Интернетээр захиалга авах, үйлчилгээ нь интернетийн сүлжээгээр төлбөртэй болон төлбөргүйгээр хүлээн авсан захиалга байна. Үүнд вэбсайт, интернет, экстранэт, интернет утас болон цахим шуудангаар хүлээн авсан захиалга, үйлчилгээ багтана. Тухайлбал, интернет худалдаа эрхлэх, интернетээр болон цахим шуудангаар бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ захиалгыг авах, интернетээр сургуульд болон сургалтын төвд бүртгүүлэх, эмнэлэгт үзүүлэх дугаар авах, онлайннар билет захиалах гэх мэт үйлчилгээ байна.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015 оны дүнгээр

4.1 Тухайн байгууллага 2015 онд үйл ажиллагаа явуулсан эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-р хариултыг сонговол 5.1-д шилжинэ.

4.2 Үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нөхнө үү.

Тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй, тодорхой бичнэ. Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC-4.0)-аас харж аймаг, дүүргийн ажлын хэсгийн гишүүд нөхнө.

4.3 Тухайн байгууллагын нийт ажиллагчдын тоог 2015 оны дундаж ажиллагчдын тоогоор нөхнө. илэрхийлэгдэнэ.

4.4 Тухайн байгууллагаас 2015 онд ажиллагчиддаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээ мян.төг-өөр бөглөнө. Цалинд буюу цалингийн фондод үндсэн цалин, нэмэгдэл, шагнал, урамшуулал орна.

Үндсэн цалин нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.

Нэмэгдэл нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.

Нэмэгдэл хөлс нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс байна.

4.5 Тухайн байгууллага 2015 онд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу “2”-аар хариуг сонговол 4.8-д шилжинэ.

4.6 Хөрөнгө оруулалтын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү.

Хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм. Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт** гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;
- **Өөрийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;
- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, буцалтгүй болон тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсаны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессийн гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мян.төг-өөр үнэлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ.

4.7 Хөрөнгө оруулалтын хэмжээг хөрөнгийн ангиллаар нөхнө үү.

Тухайн аж ахуйн нэгжийн тайлант жилд шинээр бий болсон хөрөнгийг энд хамааруулна. Үүнд:

Үйлдвэрлэгдэх хөрөнгө:

- Үндсэн хөрөнгө
 - Орон сууцны барилга
 - Орон сууцны бус барилга
 - Бусад байгууламж
 - Газар, хөрс сайжруулалт
 - Тээврийн хэрэгсэл
 - Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж
 - Тавилга, эд хогшил
 - Бусад машин, тоног төхөөрөмж
 - Биологийн өсөж, үрждэг хөрөнгө
- Оюуны өмчийн хөрөнгө:

- Геологи хайгуулын ажил, үнэлгээ
- Компьютерийн програм хангамж, мэдээллийн сан
- Оюуны өмчийн бусад хөрөнгө
- Материаллаг эргэлтийн хөрөнгө
- Үнэт зүйлс

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө:

- Байгалийн нөөц, баялаг
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лиценз

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

- Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө - Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брендийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үйлдвэрлэгдэх хөрөнгө, үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн нийлбэр дүн бичигдэнэ. Үндсэн хөрөнгийн эх үүсвэр буюу 1.5-ын “БҮГД” дүн хөрөнгө оруулалтыг ангиллаар буюу 1.6-ын “БҮГД” дүнтэй тэнцүү байна.

Жич: Дээрх үйлдвэрлэгдэх хөрөнгийн ойлголт, тодорхойлолтыг 4.12 буюу “Хөрөнгийн үзүүлэлт”-тэй ижил утгаар ойлгоно.

4.8 Санхүүжилтын эх үүсвэр, 2015 оны дүнгээр

Төрийн бус байгууллагын 2015 оны санхүүгийн эх үүсвэрийг гишүүдийн татвар, хандив, олон улсын байгууллагын төслийн санхүүжилт, засгийн газрын санхүүжилт, тусламж, банкны зээл болон бусад эх үүсвэрийг оруулан мян.төг-өөр илэрхийлж бичнэ. Бусад эх үүсвэрийн төрлийг тоологч асууж бичнэ.

4.9 Хөрөнгийн зарцуулалт, 2015 оны дүнгээр

Төрийн бус байгууллагын 2015 оны хөрөнгийн зарцуулалтыг жилийн эцсийн байдлаар тооцож нөхнө. Хөрөнгийн зарцуулалтын бусдад олгосон хандив, тусламж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, сургалт, семинар, сурталчилгааны зардал болон тэдгээрээс бусад зардлыг бусад зардалд оруулан мян.төг-өөр нөхөж бичнэ.

4.12 Хөрөнгийн үзүүлэлтийг нөхнө үү.

Тухайн байгууллагын нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл орсон дүн нөхөгдөнө.

1. **Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг 2015 оны жилийн эцсийн байдлаар элэгдэл орсон дүнгээр мян.төг-өөр тооцож нөхнө.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, газрын сайжруулалт, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил болон өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

1.1 **Орон сууцны барилгад** аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.

1.2 **Бусад барилга, байгууламж** нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ.

1.2.1 **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.

1.2.2 **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.

1.2.2.1 **Авто замыг** бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.

1.2.3 **Газар, хөрс сайжруулалт** нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна. **Газрын эзэмших эрх шилжихтэй холбогдон гарах зардлыг энд бүртгэнэ.**

1.3 **Машин, тоног төхөөрөмж** нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ.

1.3.1 **Тээврийн хэрэгсэл** нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх

- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
- төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
- нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
- усан онгоц, аяны болон спортын завь

- мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.

1.3.2 **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид** цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.

1.3.3 **Тавилга, эд хогшилд** албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.

1.3.4 **Бусад машин, тоног төхөөрөмжид** ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.

1.4 **Биологийн өсөж үрждэг хөрөнгөд** байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.

1.5 **Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал** нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

- Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
- Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;
- Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
- Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
- Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.6 Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилагдана. Үүнд:

1.6.1 **Судалгаа, шинжилгээний ажилд** хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг

багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. **Судалгаа шинжилгээ болон хөгжлийн ажлын зах зээлийн үнийг** шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.

1.6.2 Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.

1.6.3 Компьютерийн программ хангамж, мэдээллийн санд худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан программ хангамж, системийн болон хэрэглээний программ хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол программ хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, өөрсдөө боловсруулсан бол үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн зардлаар үнэлнэ.** Программ хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ.

1.6.4 Утга зохиол, урлагийн эх бүтээл нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.

1.6.5 Оюуны өмчийн бусад хөрөнгөд дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)

2. Материаллаг эргэлтийн хөрөнгө нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс байна.

2.1 Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2 Хангамжийн материал нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3 Дуусаагүй үйлдвэрлэл нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ.

2.3.1 Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсч гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор

үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2 **Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд** өсч үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлээс бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4 **Бэлэн бүтээгдэхүүнд** хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиам, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5 **Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд** аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

3. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зорилуултаар эзэмшдэг хөрөнгө байна.

3.1 **Үнэт металл, үнэт чулуу** нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2 **Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл** нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3 **Бусад үнэт зүйлсд** маркны цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засч хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

5. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

5.1 Тухайн байгууллага салбар, нэгж, төлөөлөгчийн газартай эсэхийг асууж тохирох асуултыг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу “2” гэсэн асуултыг сонговол асуулгыг дуусгана.

5.2 Тухайн байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө. Салбар, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичих ба баганад үзүүлэлтүүдийг нөхнө. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, хаягийн мэдээлэл, утасны дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноо гэсэн үзүүлэлт байна. Хаягийн хэсэгт аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хорооны нэрийг нөхөх ба “Хаяг” гэсэн баганад гудамж, хороололын нэр, байр/ байшин, хашаа/хаалганы дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноог нөхнө.

5.3 Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Тухайн байгууллагын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө. Салбар, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичнэ. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, үйл ажиллагааны чиглэлийн нэр, код, ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлого /мян.төг/, мэдээ тайлан гаргадаг эсэх гэсэн үзүүлэлтүүд байна. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нэрийг дэлгэрэнгүй нөхнө. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номноос харж нийслэл, аймгийн тооллогын ажлын хэсгийн гишүүн кодлоно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлогыг нөхөж, мэдээ, тайлан гаргадаг эсэхийг тодруулж тохирох хариултыг сонгоно. Салбаруудын 2-с 5-р баганы үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлогын дүнг БҮГД мөрөнд нэтгэнэ.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, аж ахуйн нэгжийн тамга, тэмдэгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө.

САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТООЛЛОГЫН

АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР ААНБТ-4

Тухайн асуулгын хуудсын аймаг, дүүргийн салбар, нэгж, төлөөлөгчийн газраас авах бөгөөд сум, баг, хороонд байрлах салбар, нэгж, төлөөлөгчийн газрыг аймаг, дүүргийн салбар, нэгж, төлөөлөгчийн газраар үзүүлэлтийг асууж нөхнө.

1. Хяналтын хэсэг

Тоологчийн нэр, код: Тоологч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Тоологч дугаараа нөхөхдөө тоологчийн код гэсэн баганын харгалзах 3 нүдэнд тоологчийн дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч, кодлогч, шивэгчийн үүргийг нэг хүн хавсран гүйцэтгэж болно.

Шалгагчийн нэр, код: Шалгагч асуулгын хуудсыг шалгахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шалгагч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Шалгагч асуулгын хуудасны үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон үсрэлтүүд зөв байгаа эсэхийг хянаж, тоологчтой хамтран алдааг засварлана.

Кодлогчийн нэр, код: Кодлогч нь алдаагүй зөв болсон асуулгын хуудсыг кодлохоос өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, кодлогч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Кодлогч аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гудамж, хороолол, бүсчлэлийн код, үүсгэн байгуулагдсан хэлбэр, үйл ажиллагааны чиглэл зэргийн кодлолтыг "Асуулга нөхөх заавар"-ын хавсралтыг ашиглаж хийнэ.

Шивэгчийн нэр, код: Шивэгч өөрт хуваарилагдсан тооллогын асуулгын хуудсыг компьютерт оруулахаас өмнө өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, шивэгч бүрт харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсгээс олгосон дугаарыг нөхнө. Хэрэв 2 юмуу 1 оронтой дугаар бол "01", "011" гэж өмнөх оронг "0" тавьж гүйцээн бичнэ.

Мэдээллийг компьютерт оруулах явцад алдаатай мэдээлэл илэрвэл харьяалагдах аймаг, дүүргийн тооллогын ажлын хэсэгт мэдэгдэж, засварласны дараа уг асуулгын хуудасны мэдээллийг компьютерт шивнэ.

2. Нэрийн хэсэг

Тоологч тухайн салбар, төлөөлөгчийн газрын нэр, регистрийн дугаар, толгой аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаарыг асууж нөхнө.

Толгой, охин/хараат компани, салбар төлөөлөгчийн газрын талаарх мэдээлэл

Охин/хараат компанитай гэж хариулсан бол охин/хараат компанийн нэр, регистрийн дугаар, оршин байгаа хаяг зэрэг үзүүлэлтийг нөхөж, харьяаллын хэлбэрийг 2 гэж кодолно. Тухайлбал, Таванбогд ХХК нь доороо Таван богд косметик ХХК, Таван богд хүнс ХХК, Улаанбаатар принт ХХК гэсэн 3 охин компанитай үндсэн асуулгын хуудас нь Таванбогд ХХК-ынх гэвэл 1 дүгээр асуултад “Тийм” гэж хариулах ба 2-р асуултын 1, 2, 3 дугаар мөрүүдэд Таван богд косметик ХХК, Таван богд хүнс ХХК, Улаанбаатар принт ХХК-ий нэр, регистрийн дугаар, оршин байгаа хаяг зэрэг үзүүлэлтийг нөхөж, харьяаллын хэлбэрийг 2 гэж кодолно.

- Монгол улсын Компанийн тухай хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар **Хараат компани** гэж компаний нийт энгийн хувьцааны 20-50 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хэлнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.
- Мөн хуулийн хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 3-р хэсэгт зааснаар “**Охин компани**” гэж компаний нийт энгийн хувьцааны 50-ээс дээш (51-100 хүртэл) хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг хэлнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.
- Монгол улсын Компанийн тухай” хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар “**Салбар**” нь толгой компаний оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компаний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.
- **Нэгж** – салбар болон төлөөлөгчийн газар болж чадахгүй, үндсэн аж ахуйн нэгжээс өөр газар үйл ажиллагаа явуулж буй (уурхай, мод бэлтгэл гэх мэт) нэгжийг хамруулж ойлгоно.

Салбар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан толгой компаний нэрийн өмнөөс явуулах ба толгой компани нь өөрийн салбар компанийн хүлээх үүргийг хариуцна.

Салбарын охин/хараат компаниас ялгагдах онцлог нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй. Харин түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

Төлөөлөгчийн газар нь компаний оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компаний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компаний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

3. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын хаягийн хэсэг

Тухайн салбар, төлөөлөгчийн газрын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, хашаа, хаалганы дугаар, бүсчлэлийн нэрийг нөхнө. Тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж кодлогч нөхөх ба хэрэв тухайн салбар, төлөөлөгчийн газрын оршин байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн нэр нь хавсралтад байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй, түүнийг нэмэх шаардлага гарвал УБСЕГ-ын ААНБ-ын тооллогын ажлын хэсгийн гишүүдтэй холбоо барьж тохиролцсоны үндсэн дээр кодолно. Мөн тоологч энэ хэсэгт салбар, төлөөлөгчийн газрын утасны дугаар, факс, шуудангийн хайрцаг, цахим шуудан, цахим /веб/ хуудасны нэрийг асууж нөхнө.

4. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын дарга/захирлын мэдээлэл

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын дарга/захирлын овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг асууж нөхнө.

5. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын харьяаллын хэлбэрийг тодорхойлно уу.

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын харьяаллын хэлбэрийг асууж тохирох хариултыг сонгоно.

6. Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээ, тайлан гаргадаг эсэхийг асууж тохирох хариуг сонгоно.

7. Тухайн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичнэ.

Үйл ажиллагааг ихээс бага руу хуваарилах аргаар (Top-down method) тодорхойлно. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл бүрийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн эсвэл борлуулалтын орлоготой нэгжийн үйл ажиллагааг бага руу хуваарилах аргаар үндсэн үйл ажиллагааг тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номноос харж аймаг дүүргийн ажлын хэсгийн гишүүн нөхнө.

Ажиллагчдын тоо нь 2015 оны дундаж ажиллагчдын тоо байх ба үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог салгаж нөхнө.

2015 онд тухайн нэгжээс ажиллагчиддаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээг мян.төг-өөр илэрхийлж бичнэ. Цалинд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал оруулна.

- **Үндсэн цалин** нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.
- **Нэмэгдэл** нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.
- **Нэмэгдэл хөлс** нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.

Үйл ажиллагааны орлогод барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэсэн орлогыг оруулна. Үйл ажиллагааны орлогыг мян.төг-өөр илэрхийлж бичнэ.

8. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

Энэ асуулга тухайн аймаг, дүүрэгт байрлах салбар, нэгж, төлөөлөгчийн газрын сум, хороо, багт байрлах салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө.

Салбар, нэгж, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичнэ. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, сум/дүүрэг, баг/хорооны нэр, ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлого /мян.төг/, мэдээ тайлан гаргадаг эсэх гэсэн үзүүлэлтүүд байна.

Салбаруудын 1-с 4-р баганы үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлогын дүнг БҮГД мөрөнд нэтгэнэ.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, байгууллагын тамга, тэмдэг даруулж баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө.

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БАЙРШЛЫГ

ГАЗРЫН ЗУРАГТ ТЭМДЭГЛЭХ ЗААВАР

1. Тоологчийн газрын зургийг ашиглах зорилго

- 1.1. Тооллогын нэгжийн байршлыг тодорхойлох;
- 1.2. Тооллогын нэгжийг тооллогод бүрэн хамруулах;
- 1.3. Тооллогын нэгжийн хамрагдалтыг шалгах, хянах;


2. Ач холбогдол

- 1.1. Тооллогын нэгжийн байршлыг нарийн тодорхойлох;
- 1.2. Тоологч өөрийн хариуцах тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн тооллогын нэгжийн хамрагдалтыг хянах;
- 1.3. Тоологч өдөр бүрийн тоолох ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тооллого хийх нутаг дэвсгэрийнхээ хаанаас эхэлж хаагуур явах маршрутаа тогтоох;

3. Газрын зураг дээр ажиллах заавар

- 3.1. Тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлох, тоологчоор хуваарилах.

Аймгийн тооллогын комисс, хорооны тооллогын ажлын хэсэг тоологчийн хариуцаж тоолох нутаг дэвсгэрийг хуваарилж, тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлж хил заагийг хүргүүлсэн газрын зурагт тэмдэглэх бөгөөд тоологч зөвхөн тэрхүү хуваарилсан нутаг дэвсгэр дэхь аж ахуйн нэгжийг тоолно. Ингэхдээ нэг тоологчийн тоолох аж ахуйн нэгжийн тоог тооцсоны дүнд нутаг дэвсгэрийг хуваарилна.



Зураг 1. Тооллогын нутаг дэвсгэрийг тоологч бүрээр хуваарилсан байдал.

Харин сумын тооллогын ажлын хэсгийн хувьд 2 ба түүнээс дээш тоологч ажиллахгүй тохиолдолд тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлж хил заагийг газрын зурагт дүрслэх ажил хийгдэхгүй.

3.2. Газрын зургийг унших, нэмэлт тэмдэглэгээ хийх.

Тоологч газрын зураг дээрх хашаа, гэр, орон сууц, нийтийн байр гэх мэтээр байршил нь тэмдэглэгдсэн аж ахуйн нэгжийг тоолохоос гадна кадастрын зурагт ороогүй байшин барилга, орон сууц, нийтийн байр, объект зэрэгт байгаа аж ахуйн нэгжийг тоолж, байрлаж байгаа сууцыг газрын зурагт нэмж тэмдэглэнэ. Өөрөөр хэлбэл, тооллоын комисс, ажлын хэсгээс хуваарилсан газар нутгийн хил доторх зурагт тэмдэглэгдсэн болон тэмдэглэгдээгүй бүх аж ахуйн нэгжийг тоолж, газрын зурагт тэмдэглэнэ.


3.3. Аж ахуйн нэгжийн байршлыг тэмдэглэх хугацаа.

Аж ахуйн нэгжийн байршлыг тухайн аж ахуйн нэгж дээр очиж асуулгыг авсны дараа **тэр өдөртөө** газрын зураг байрлаж буй газар болох тооллогын комисс, ажлын хэсэг дээр ирж байршлыг тэмдэглэнэ. Энэ ажлыг тоологч тухайн өдрийн аж ахуйн нэгжийн байршлаа сайн санаж байх, олон хоногийн дараа бүх аж ахуйн нэгжийн байршил тэмдэглэж өөртөө ачаалал үүсгэхгүй байлгах зэрэг давуу талтай байдгаас хамаарч **өдөр бүрийн тооллогын дараа** тэмдэглэх хэрэгтэй.

3.4. Аж ахуйн нэгжийн байршлыг тэмдэглэх.

Газрын зурагт байршил тэмдэглэхдээ дараах заавруудыг баримтлана.

Байршлыг зөв, тодорхой, нарийвчлал сайтайгаар зөвхөн **цэглэж** тэмдэглэнэ.



Зураг 2. Аж ахуйн нэгжийн байршлыг **цэглэж** тэмдэглэсэн байдал.


Цэглэхээс өөрөөр (том бөөрөнхий, цагариг, таван хошуу, дөрвөлжин, гурвалжин гэх мэт) тэмдэглэхийг хориглох бөгөөд тэмдэглэсэн тохиолдолд тухайн байршлыг буруу буюу хүчингүй гэж үзнэ.

- Аж ахуйн нэгжийн байршлыг тэмдэглэсэн цэгийн хажууд тухайн аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг бүтнээр нь бичсэн байна.



Зураг 3. Аж ахуйн нэгжийн байршлын цэгийн хажууд регистрийн дугаарын бичсэн байдал


- Аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг аж ахуйн нэгжийн байршил тэмдэглэсэн цэгийн хажууд бичих боломжгүй тохиолдолд **дугаар бичих зайтай хоосон хэсэгт** тухайн аж ахуйн нэгжийн зурган дээрх хаяг, байшин, хашаа, хаалганы дугаар зэрэг тухайн ААН-ийн зураг дээрх **байршлыг тодорхойлж болох үзүүлэлтийн хамт бичиж болно.**



Зураг 4. 11-р байранд байрладаг аж ахуйн нэгжүүдийн байршлыг тэмдэглэсэн байдал.

Энэ тохиолдолд тухайн аж ахуйн нэгжүүдийн регистрийн дугаарыг бичиж дууссаны дараа бусад аж ахуйн нэгжийн регистрийн дугаартай холилдуулахгүй байх, ялгах үүднээс дөрвөлжин хүрээгээр хашиж өгөх хэрэгтэй.


- Мөн нэг барилга байгууламж дээр олон тооны аж ахуйн нэгж байрлаж байгаа тохиолдолд тухайн аж ахуйн нэгжүүдийн байршлыг төлөөлүүлэн байршлын нэг цэг тэмдэглэж аж ахуйн нэгж бүрийн дугаарыг нэг цэгийн хажууд (эсвэл тойруулан) бичиж болно.



Зураг 5. Нэг газар байрлаж буй олон аж ахуйн нэгжийн байршлыг нэг цэгээр төлөөлүүлэн тэмдэглэсэн байдал. /Энэ тохиолдолд аж ахуйн нэгжүүдийн РД-г заавал бичнэ/

- Газрын зургийн тухайн объект дээр олон тооны аж ахуйн нэгж байршиж байршлын цэг болон регистрийн дугаарыг багтааж бичих боломжгүй бөгөөд тухайн аж ахуйн нэгжийн газрын зураг дээрх хаяг байршлыг илэрхийлэх мэдээлэл байхгүй тохиолдолд газрын зураг дээрх аж ахуйн нэгжүүд байршиж буй объектыг тоологч өөртөө ойлгогдохуйц байдлаар дугаарлаад газрын зургийн хоосон зайд тухайн объектын дугаарыг бичээд түүнийхээ араас байрлаж буй аж ахуйн нэгжүүдийн регистрийн дугаарыг бичиж болно. Өөрөөр хэлбэл газрын зургийн нэг объект дээр олон аж ахуйн нэгжийн цэг, регистрийн дугаарыг багтаан бичих боломжгүй бол тухайн объектыг тоогоор төлөөлүүлэн дугаарлаад хоосон зайд тухайн тоо бүхий объектод байрлаж буй аж ахуйн нэгжүүдийн регистрийн дугаарыг төлөөлүүлсэн тооны хамт бичиж болно.

Аж ахуйн нэгж байгууллагын 2016 оны тооллого
Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян баг



Зураг 6. Аж ахуйн нэгжүүдийн байрлаж буй байрлалуудыг дугаарлан, тухайн дугааруудын ард байрлаж буй аж ахуйн нэгжүүдийн РД-г бичсэн байдал.

3.5. Тооллогын газрын зургийн хадгалалт, аюулгүй байдлыг хангах.

Тооллогын газрын зураг нь тооллогын асуулгын хуудастай адил чухал баримт материал учир түүнийг гэмтэх, урагдах, хаягдаж гээгдэхээс сэргийлж байх хэрэгтэй. Тооллогын газрын зургийг Аж ахуйн нэгжийн тооллогод ашиглахаас өөр зориогоор ашиглахыг хориглоно.

----- оОо -----